

БАРУУН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ГАРЦ: ГУРВАН ТАЛТ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ

Проф. Ц.Баатар¹

The relations in the triangle-Mongolia-Russia-China never have been bettering history. The problem is that there is no major political or economic issue between the three neighbors.

The Government of Mongolia, with the objective of improving its internal transport network and increasing trade and transit links between Mongolia and its neighboring countries, the People's Republic of China (PRC) and the Russian Federation, has undertaken the upgrading of the Western Regional Road Corridor(WRRC).The WRRC connecting Yarant at the Mongolia/China border and Ulaanbaishint at the Mongolia/Russia border is strategically important for the socioeconomic and regional development of Mongolia, as well as improving relationships with neighboring countries. The outcome of the project will be an efficient and safe regional transport route that is developed in the Western Region of Mongolia, linking Xinjiang Autonomous Region in the PRC and the Siberia region of the Russian Federation by way of Khovd and Bayan-Olgii aimags of Mongolia. WRRC also includes a section of Asian Highway 4 (AH4), an internationally designated road by the United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (UNESCAP).

The Western Mongolia is most important component of trilateral cooperation. The effective joining of the Silk Road Economic Belt, the Prairie Road, and Trans-Eurasian Belt Development will boost the building of the China-Russia-Mongolia economic corridor and promote practical cooperation projects including railways, roads, energy resources, logistics, gas pipelines, transportation and agriculture. This will effectively promote the building of China-Russia-Mongolia economic corridor and boost the regional economic cooperation and development of the entire Eurasian continent.

1. ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн ЭШАА, ШУ-ны доктор (Sc.D)

Баруун бүс

Монгол улсын тогтвортой хөгжлийн стратеги болон Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийг баруун бүсэд хамруулсан байдаг. Энэ 5 аймаг нийт 91 сумтай, 415.7 мян.ам метр газар нутаг буюу манай улсын нийт нутаг дэвсгэрийн 26.6 хувийг эзэлнэ². Баруун бүс 456 мянга гаруй хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 200 мянга орчим бөгөөд энэ оны эхний хагас жилийн байдлаар ажилгүйдлийн түвшин 9.8 хувьтай байна³. Баян-Өлгий аймагт ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр буюу 30 хувьтай байна⁴. Баруун бүсэд манай улсын нийт малчдын 30-аад хувь нь амьдарч, нийт мал сүргийн 28.1 хувь, тариалангийн талбайн 4.5 хувь тус тус ногдож, улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 7.3 хувийг үйлдвэрлэдэг. Бүсийн эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй юм. Энд үйлдвэрлэл хөгжөөгүй, мал аж ахуй дээр суурилж амьжиргаагаа залгуулдаг, шилжилт хөдөлгөөн хамгийн их зэрэг хүндрэлтэй асуудал олон бий. Тухайлбал, баруун бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 58.4 гаруй хувийг ХАА-н салбар, 36.3 хувийг үйлчилгээний салбар, 5.2 хувийг аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна⁵. Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ Улаанбаатар хотын энэ үзүүлэлтээс 3.6 дахин бага, Хангайн бүсийн энэ үзүүлэлтээс 1,7 дахин бага, улсын дунджаас 2.2 дахин бага байгаа аж. Түүнчлэн нэг хүнд ногдох ДНБ, боловсролын байдал, хүн амын дундаж наслалт, ажилгүйдлийн түвшин, эрчим хүчний хангамж, төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн коэффициент, хүний хөгжлийн индекс зэрэг шалгуур үзүүлэлтийг тооцон аймаг, хот, бүсүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний нэгдсэн үнэлгээг хийж үзэхэд Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд аймгийн хөгжлийн ерөнхий түвшин Улаанбаатар хот, Орхон аймгийнхаас ойролцоогоор 9 дахин, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийнхаас 3-4 дахин доогуур байна. Булган, Дундговь, Дорнод аймгийн хөгжлийн ерөнхий түвшин Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд аймгийнхаас дунджаар 2 дахин дээгүүр, харин Улаанбаатар хот, Орхон аймгийн энэ үзүүлэлтээс

2. Ё.Гантоого. Баруун бүсийн хөгжлийн хандлага төлөв

3. /<https://uvs.nso.mn/uploads/>

4. / <http://www.bayan-olgi.gov.mn/pages/>.

5. /news.gogo.mn/r/108854/

4 дахин доогуур байна гэсэн судалгаа гарчээ⁶. Эдийн засгийн бүсүүдийн хооронд ч хөгжлийн ерөнхий түвшний ялгаа их байгааг дараах судалгаа харуулж байна⁷.

Эдийн засгийн макро бүсүүдийн хөгжлийн түвшний харьцуулсан үнэлгээ

| Бүсийн нэр | Баруун | Зүүн | Хангайн | Төвийн | Улаанбаатар |
|------------------------|--------|------|---------|--------|-------------|
| Үнэлгээний коэффициент | 1,00 | 1,50 | 2,40 | 2,80 | 7,50 |

Өнөөгийн байдлаар баруун бүсийн эдийн засгийн үзүүлэлт бусад бүсүүдтэй харьцуулахад доогуур байгаа хэдий ч ойрын ирээдүйд Монгол улсын өсөлт хөгжлийн нэгэн тулгуур бүс болох асар их нөөц боломж бий. Тухайлбал нөөц нь тогтоогдсон заримынх нь ТЭЗҮ нь бэлэн болсон Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгө, Ховд аймгийн Халзан бүргэтэйн газрын ховор элемент, Завхан аймгийн Баян-Айрагийн зэс, алт, Говь-Алтай аймгийн Талын мэлтэсийн алт, Увс аймгийн давсны орд зэрэг томоохон нөөц бүхий газруудыг түшиглэн олборлох, ашиглах, боловсруулах үйлдвэрүүд байгуулах 4,1 их наяд төгрөг буюу 2.9 тэрбум ам.долларын төслүүд хөрөнгө оруулалтаа хүлээж байна⁸. Энэ дашрамд нэмж тэмдэглэхэд үе үеийн геологичдын анхаарлыг татсаар ирсэн Их нууруудын хотгор баруун бүсэд оршдог. Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын нутаг дэвсгэрийг хамарсан энэ их ай сав газарт хэдэн арван тэрбумаар хэмжигдэх газрын тосны нөөц бий гэсэн таамаглал бий. Гэхдээ магадлалын онолоор бол нефтийн том нөөц байх боломжтой гэдгийг геологичид үгүйсгэдэггүй. Бодит нөөцийг тогтоох эрэл хайгуулын ажил хараахан эхлээгүй л байна.

Баруун бүсийн хөгжлийн гарц

Баруун бүсийн байгаль-экологи, эдийн засаг, нийгмийн дээрхи хүчин зүйлсийн үнэлгээ хийгээд хоёр хөршөө холбож өгөх тээвэр-газарзүйн тохиромжтой байрлал, өргөн уудам газар нутаг, мал аж ахуйн түүхий эдийн болон эрдэс баялагийн нөөц, хөдөлмөрийн идэвхижил харьцангуй сайтай, хямд ажиллах хүч зэрэг олон давуу талуудыг

6. www.openforum.mn > ... > Нийгэм, эдийн засаг > Бүс нутгийн хөгжил

7. Л.Цэдэндамба “Монголын бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлууд”

8. forum.mn/en/ Ч.Хашчулуун, Р.Анхбаатар/.

зохистой ашиглах явдал өнөөдөр энэ бүсийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа билээ.

Дээрх давуу тал, бодит хүчин зүйлсийг үндэслэн Бүсчилсэн хөгжлийн стратегид “Баруун бүсээр дамжуулан ОХУ, БНХАУ, улмаар өрнө, дорнын орнуудтай холбосон дэд бүтцийн сүлжээг сайжруулах үндсэн дээр Өлгий-Цагааннуур, Улаангом-Боршоо, Ховд-Ярантай(Булган), Алтай-Бургалтай, Улиастай-Арцсуурийн чиглэлээр гадаад худалдаа-тээврийн цогцолборуудыг байгуулж, олон улсын хамтын ажиллагааны бүс нутгийн сүлжээг хөгжүүлэх бодлого баримлана” гэж тодорхойлсон⁹. Хөгжлийн стратегийн энэхүү бодлого зорилтыг гурван талт стратегийн түншлэлтэй уялдуулан хэрэгжүүлэх хамтын ажиллагааны механизм, эрх зүйн нэн таатай орчин өнөөдөр үндсэндээ бүрдсэндээ бүрдээд байна.

Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Монгол Улс нь өөрийгөө, ОХУ-ын хувьд Европоос Ази руу гарах, БНХАУ-ын хувьд Азиас Европ руу гарах хамгийн дөт, найдвартай дамжин өнгөрөх дэд бүтцийн зангилаа орон гэж үздэг юм”¹⁰ гэж Монгол улсын гурван талт түншлэлийн харилцаанд баримтлах байр суурийг маш тодорхой томъёолон илэрхийлсэн билээ. Уфагийн уулзалтаар гурван улсыг холбосон транзит тээврийн буюу дэд бүтцийн мега төслийг хөдөлгөх тал дээр гурван улс төрийн дээд түвшинд бүрэн ойлголцолд хүрсэн гэж үзэж болно. Үүнтэй холбогдуулан хөрш гурван орны стратегийн түншлэлийн нэгэн хувилбар болгож Баруун бүсийн босоо тэнхлэгээр уялдуулан хөгжүүлэх боломж, урьдчилсан нөхцөл бүрдсэн эсэх талаар судалгааны энэхүү өгүүллийн зорилго болно.

Нэг. Хурдны авто зам

Монгол Улс 2004 онд НҮБ-ын Ази, Номхон далайн Нийгэм эдийн засгийн комиссын гишүүн орнуудын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Азийн хурдны авто замын сүлжээнд нэгдэн орохдоо Ази-Европыг холбох АНЗ, АНЗ2 болон АН4 гэсэн 3 чиглэлийн өндөр хурдны авто замуудыг өөрийн нутагтаа барьж байгуулах үүрэг хүлээсэн. Үүний баруун бүсээр хоёр хөрш хийгээд Ази-Европыг холбох хурдны авто замыг Баруун бүсийн босоо тэнхлэгийн хурдны авто зам 4А гэж нэрлэдэг. АН4 (Улаанбайшинт-Өлгий-Ховд -Ярант) чиглэл

9. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

10. www.president.mn/

нь баруун бүсийг дайран өнгөрөх энэ зам нь Монгол улсын хойгуур өнгөрөх ТРАНССИБИРЬ - магистрал, урдуур өнгөрөх ТРАСЕКА-олон улсын магистрал (өрнөөс дорно хүрэх) хоёрыг холбож байгаагаараа онцгой чухал ач холбогдолтой.

Хурдны зам ашиглалтанд орсноор Пакистаны Карачи, Исламабад, БНХАУ-ын Үрэмч, Тайкешкен, Ховд, Баян-Өлгий аймгууд, ОХУ-ын Новосибирск хот гэсэн маршрут бүхий, 6000 км урт, Ази-Европыг холбосон хурдны замын сүлжээ бий болох юм¹¹. Монгол улс энэ сүлжээнд нэгдсэнээр худалдаа, тээврийн хүчин чадал нэмэгдэн, орон нутгийн хөгжилд дорвитой нэмэр үзүүлэх давуу тал, хөгжлийн боломж олгох юм.

Хоёр хөршийг баруун босоо тэнхлэгээр холбох гол судас, баруун бүсийн хөгжлийн нэгэн тулах цэг, хөгжлийн гарц болсон энэ их бүтээн байгуулалт 2010 оноос эхлэн үе шаттайгаар амжилттай хэрэгжиж байна. Хурдны авто зам А 4 буюу Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 743.1 км авто замын энэ том төслийн нийт санхүүжилтийн 45 хувийг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, 27 хувийг БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл үлдсэн 18 хувийг Монгол Улсын Засгийн газар гаргаж байна. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар олон улсын өндөр хурдны авто замын стандартад нийцсэн 560 орчим км замыг барьж ашиглалтанд бүрэн оруулаад байна¹². Ховд аймаг Хятадын Шинжаан-Уйгарын өөртөө засах орны Тайкешкэнтэй хурдны авто замаар өнгөрсөн оны 10 дугаар сард холбогдлоо. Хурдны авто замын үлдсэн хэсэг болох Ховдоос Баян-Өлгий аймгаар дайрч, Улаанбайшинтаар ОХУ-ын хилд хүрэх 165 км замын бэлтгэл ажлыг хангаж, санхүүжилтийг шийдэж, барих компаниудыг сонгон шалгууруулаад байгаа бөгөөд ирэх 2 жилд буюу 2017 он гэхэд ашиглалтанд бүрэн хэмжээгээр оруулах зорилт тавьж ажиллаж байна¹³. Ийнхүү Ази-Европыг холбосон олон улсын транзит ачаа, зорчигч тээврийн шинэ корридор т баруун бүс холбогдсноор Монгол улсын хөгжлийн нэгэн гарц нээгдэх цаг хугацаа тун ойрхон байна. Энд нэмж тэмдэглэхэд босоо тэнхлэгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд Монгол улсын хөгжлийн бодлогод ойрын хугацаанд

11. www.adb.org/countries/subregional.../carec

12. “Засгийн газрын мэдээ” сонин. 2015.07.20

13. <http://jargaldefacto.com>

хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Улаан байшинтад Ачаа тээврийн ложистик байгуулах төсөл чухал ач холбогдолтой. Гурван улсын хамтарсан тээвэр-ложистикийн компани байгуулах зэрэг томоохон төслийг хэрэгжүүлэх бодит ажлыг ойрын хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатайг гурван улсын төрийн тэргүүн нар Уфад болсон уулзалтын үеэр тэмдэглэсэн. Улаанбайшинтад Ачаа тээврийн ложистик байгуулах төслийг дээрхи төслийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Босоо тэнхлэгийн үр ашгийг өсгөн нэмэгдүүлэхэд ОХУ болон БНХАУ-ыг холбох хамгийн дөт зам Улаанбайшинтаас Даянгийн боомт хүртэлх авто зам юм. Энэ авто замын урт ердөө 212 км. Энэ замыг барьсанаар хоёр хөршийг хоёр гарцаар холбох боломж нээгдэх төдийгүй Монгол Улсын хувьд Төв Азийн улс орнууд руу гарах нэн чухал стратегийн ач холбогдол бүхий шинэ гарц бий болох юм.

Босоо тэнхлэгийн хурдны авто зам хүлээгдэж байгаа томоохон төслүүдийг хөдөлгөх нэн таатай боломж олгож байна. Тухайлбал, Босоо тэнхлэгт хамгийн ойр байрлалтай Асгатын 7369.8 тонн мөнгөний нөөцтэй, ТЭЗҮ-нь бэлэн болсон ордыг энд нэрлэж болох байна. “Асгатын мөнгөний орд”-д Оросын хил дамжихгүйгээр хүрэх далайн төвшнөөс дээш 3500-3600 метрийн өндөрт 7.3 км хатуу хучилттай авто зам, 72.8 метр урттай бетон гүүрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж 2013 онд ашиглалтанд оруулснаар ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах бодит нөхцөл бүрдсэн. Асгатын ордыг түшиглэн уурхай, баяжуулах фабрик, металлургийн үйлдвэр, 15-20 мвт-ын дулааны цахилгаан станц барьснаар 1000 гаруй хүн ажлын байртай болж, жилд 300-500 мян. тн хүдэр боловсруулахад (зэс, мөнгө, бусад дагалдах элемент) ихээхэн ашигтай ажиллах тооцоо бий¹⁴. Эрэлттэй зах зээл хаана байна тэнд нь хүргэж тээвэрлэх зам нь бэлэн болжээ. Гурван талт стратегийн түншлэлийг ч энэ том төсөлтэй холбож болох юм.

Баруун босоо тэнхлэгийг угтуулан баруун таван аймгийг хэвтээ тэнхлэгээр нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох орон нутгийн замын бүтээн байгуулалт ч Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд амжилттай хэрэгжиж байна. 2013-2014 онд баруун таван аймагт 750 гаруй км хатуу хучилттай авто зам ашиглалтанд оруулсан

14. tsag.mn/2221-asgатын-ord-73698-tonn-mngniy-nctey.html

байна. 2016 он гэхэд энэ таван аймгийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох зорилт тавин гүйцэтгэгч компаниудтай концессийн гэрээ байгуулан ажиллаж буй аж. Дээрхи зорилтууд хэрэгжсэнээр Баруун бүсийн таван аймаг баруун босоо тэнхлэгтэй холбогдож, нийгэм эдийн засгийн илүү эерэг таатай орчин бүрдэхээс гадна энэ бүс нутаг чиглэх гадны хөрөнгө оруулалт нэмэгдэж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж, эдийн засгийн тогтвортой бөгөөд нэн таатай эрүүл орчин нөхцөл бүрдэх юм. Энэ бүхэн гурван талт стратегийн түншлэлийг Баруун бүсээс эхлэх суурь нөхцөл нэгэнт бүрдсэн болохыг харуулж байна.

Хоёр. Байгалийн хий дамжуулах баруун шугам “Сибирийн хүч-2”(Алтай төсөл)

Урд хөршийн “нэг бүс, нэг зам” гэсэн стратегийн “Бүс” гэдэг нь Хятадын Шинжаан-Уйгарын өөртөө засах орноос Төв Азиар дайран ОХУ, Европ руу хурдны авто зам, төмөр зам, газрын тос, байгалийн хийн хоолой, эрчим хүч болон бусад дэд бүтцийн сүлжээг босгох мега төслүүд орж буй гэж бид ойлгож байгаа. Баруун босоо тэнхлэгээр холбогдох хоёрдахь гарц нь Оросоос Хятад руу татах “Байгалийн хий дамжуулах баруун шугам-“Сибирийн хүч-2” буюу (Алтай төсөл)-ийг баруун бүсийн нутаг дэвсгэрээр дамжуулан тавих Монголын талын санал юм. Удаа дараа тавьж ирсэн энэ саналыг гурван талт стратегийн түншлэлийн хүрээнд харилцан ашигтай байх нөхцөлөөр хэрэгжүүлэх өргөн боломжбий. Ташантаар дамжуулан хийн хоолой татах хувилбарыг монгол, оросын эрдэмтэд, шинжээчид хоёр улсын төдийгүй гурван хөршийн ашиг сонирхолд бүрэн нийцнэ гэж үздэг. Оросын эрдэмтэд энэ алтернатив хувилбар нь Оросын газар нутгаар хийн хоолой тавих ажиллагаа мэдэгдэхүйц хялбаршина гэж тооцсон. Учир нь Кош-Агачаас Ташанта боомт хүртэл 50 км авто замтай. Улаанбайшинт хүртэл тавьж буй хурдны авто замын дагуу Оросоос Хятад руу чиглэсэн хийн хоолойг Баян-Өлгий аймгаар дайруулан тавихад арай урт зайг туулах боловч орчны болон цаг уурын нөхцөл нь Алтайн өндөр уулсаар дамжуулснаас хамаагүй ашигтай илүү хямд төсөр, илүү аюул багатайн дээр газар хөдлөлтийн аюултай бүс болон мөнхийн цэвдэгт Укокийн хавтгайн 2600 метрийн өндөрт хийн хоолойг татна гэдэг нь техникийн үндэслэлгүй гэсэн дүгнэлт гаргажээ. Одоо гурван талын байр суурь,

нөхцөл байдал нэгэнт тодорсон болохоор энэ хувилбарыг шинээр авч үзэх боломжтой. Хийн хоолойн Монголын хувилбарыг хэрэгжүүлэх тохиолдолд гурван талд харилцан ашигтай байхаар хил гаалийн болон эдийн засгийн нөхцөлөөр тохиролцож болно гэж үзэж байна. Төслийн цар хүрээгээр аваад үзвэл микроскопоор л харах хэмжээний жаахан хийгээр л Монголын талд дамжин өнгөрүүлсний төлбөр хийх аж. Энэ мега төслийн хэрэгжилт нь экологи, нийгэм-эдийн засгийн болон бусад ямарваа нэгэн асуудлыг дагуулахааргүй байх боломж нөхцлийг гурван талт стратегийн түншлэлийн хүрээнд хангах бүрэн боломжтой. Хэдийгээр Хятадын тал Зүүн бүсийн төсөлд түлхүү ач холбогдол өгч байгаа хэдий ч «Газпром» -ын тэргүүн Алексей Миллерын саяханы хэвлэлд өгсөн мэдээллээс үзэхэд Хятад улстай “Сибирийн хүч-2” буюу (Алтай) төслийн гэрээнд 2016 оны хавар гэхэд гарын үсэг зурах боломж нөхцөл бүрдэнэ гэсэн хүлээлттэй байгаа аж¹⁵

Дүгнэж хэлэхэд Оросын хийн транзит хоолойг Монголын баруун бүсээр дамжуулах нь гурван талт түншлэлийн стратегийг хэрэгжүүлэх улс төр, эдийн засаг, соёлын олон чухал тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх өргөн боломжийг олгоно. Жишээлбэл, ирээдүйд бий болох хоёр болон гурван талын хөрөнгө оруулалттай хамарсан үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний хангамж, дэд бүтцийн асуудлыг шийдэх боломж нээгдэнэ. Түүнчлэн Монгол улс хоёр хөршийн хамт Евроазийн геополитик, эдийн засаг, соёлын интеграцчилалд нэгдэх, үндэсний ашиг сонирхлоо хамгаалсан харилцан итгэлцэлийг бэхжүүлэх төдийгүй, шинэ зууны хөгжлийн стратегийн дуудлага болсон байгальд ээлтэй ногоон эдийн засгийн зарчимд суурилсан интеграцчилалд ч том хүчин түлхэцийг үзүүлнэ.

Гурав. Хил дамнасан чөлөөт бүс

Гурван талт стратегийн түншлэлийг баруун бүсээр хөгжүүлэх боломжит хувилбарт гурван улсын хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудал байж болох байна. Ийм нөхцөл боломж ч бүрдсэн гэж үзэж байна. Баруун бүс босоо тэнхлэгээр хоёр хөрштэйгээ холбогдсоноор гурван улсын хил залгасан бүс нутгуудын түүх соёл, хэл, зан заншлаараа холбоотой Хятадын Алтай аймаг, ОХУ-ын Алтайн хязгаарын хотууд: Барнаул, Биск, Новосибирск болон Алтайн БН улс, Тува, Хакастай

15. www.vz.ru/news/2015/9/3/764889.html/

худалдаа, эдийн засгийн уламжлалт харилцан итгэлцэлд тулгуурласан найрсаг харилцаа, гурван улсын иргэдийг холбосон баг бэх холбоос нь энэ бүс нутагт хил дамнасан Чөлөөт бүс байгуулахад давуу тал болж өгнө. Нөгөө талаас, БНХАУ-ын баруун хойд муж /тухайлбал Шинжаан-Уйгарын Өөртэй Засах Орон, 30 сая хүн амтай / сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа учраас манай улсын баруун бүсээр дамжин ОХУ-аас ашигт малтмал, түүхий эд материал, мод авч оронд нь өргөн хэрэгцээний төрөл бүрийн бараа нийлүүлэх сонирхолтой. Харин ОХУ-ын Алтайн хязгаарын БН улс /10 орчим сая хүн амтай/ Хятадын хямд бараа, бүтээгдэхүүнийг аль болох дөт замаар авах боломжийг эрэлхийлдэг.

АН-4 болон Даян-Улаанбайшинтын зам ашиглалтанд орсноор Монголын баруун бүсээр дамжин өнгөрөх худалдааны асар их урсгал бий болно. Нөгөөтэйгүүр далайн тээвэрлэлтийн хугацааг 2-3 дахин багасгаж, зардлыг бууруулах боломжтой гэсэн тооцоо судалгаа байдаг. Баруун бүсэд гурван улсын “хил дамнасан чөлөөт бүс” байгуулах боломжийг судлах асуудлыг Гурван талт стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрт хамруулах нь гурван талт түншлэлд харилцан ашигтай байх нэг нөхцөл байж болох юм.

Түүнчлэн Монгол Улс худалдааны түнш орнуудтайгаа Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудал чухлаар тавигдаж байгаа өнөө үед энэ хэлэлцээрийн урьтал нөхцөл болгох маягаар “хил дамнасан чөлөөт бүс” байгуулж буй орнуудын туршлагыг судлах зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал, БНХАУ, Казахстаны хилийн бүст байгуулагдсан Хоргосын чөлөөт бүс нь бидний судлах ёстой хамгийн ойрын жишээ. Энэ бүс нь БНХАУ-ын Төв Ази, Өмнөд Ази, цаашлаад Европ руу гарах гол гарцуудын нэг гэж тооцогддог, олон улсын зэрэглэлийн эдийн засгийн нээлттэй бүс бөгөөд боловсруулах үйлдвэрийг голлон хөгжүүлэхээр төлөвлөжээ. Монгол улсын хувьд Төв Азийн Казакстан, Киргизстан, Узбекистан, Туркменстан Азербайжан, Армен, Гүрж зэрэг улс орон багтсан том зах зээлийг онцлон авч үзэх цаг болсон. Бидэнд энэ зах зээл рүү гарах давуу тал бий. Бид тэдэнтэй түүхээрээ холбогдож байсан улс төдийгүй хуучин тогтолцооны үеийн худалдаа эдийн засгийн харилцааны уламжлалтай. Төв Азийнханы хэрэглээ монголчуудтай төстэй. Гахайн махнаас илүү адуу, үхэр хонины

мах хүнсэндээ түлхүү хэрэглэдэг энэ зах зээл рүү хэрэглээ, түүхээрээ, уламжлалт харилцаагаараа дамжаад холбогдох бүрэн боломж бий. Энэ боломжийг ашиглах гарц нь хил дамнасан чөлөөт бүс байгуулах явдал гэж үзэж байна.

Дөрөв. Аялал жуулчлал

Баруун бүсийн босоо тэнхлэгт түшиглэн олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж бий. Монгол, Орос, Хятад, Казакстан гэсэн дөрвөн улсыг зааглан 3000 гаруй км сунаж тогтсон Алтайн нуруу бол унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай говь хосолсон байгалийн сонин тогтоц, олон ястан угсаатны түүх, соёл, ахуй, зан заншил зэрэг нь аялал жуулчлалыг хөгжүүлэх ихээхэн нөөц боломжтой. Баруун бүс нь Алтайн уулсыг тойрсон олон улсын аялал жуулчлалын цагираг дээр байрладаг давуу талтай. Энэ давуу талыг хамгийн сайн ашиглаж байгаа улс гэвэл одоогоор ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах улс. Алтайн Бүгд Найрамдах улс 206 мянга гаруйхан хүн амтай хэдий зөвхөн зуны улиралд үзэсгэлэнт онгон байгалиа түшиглэн экологийн, соёл-танин мэдэхүйн аялал-экскурс, авто замын, явган, морин болон усны аялал, уулчид, анчид, казино зэрэг олон чиглэлээр жил бүр дундажаар нэг сая гаруй жуулчдыг хүлээн авч төсвийн орлогын голыг бүрдүүлдэг байна¹⁶.

Манай баруун бүс дээрхи давуу талаа түшиглэн аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэх санаачлагыг саяханаас л дөнгөж эхэлж байна. Баруун бүсэд “Алтай бидний нийтийн гэр” гэсэн уриатай хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх стратегийн бодлого амжилттай хэрэгжиж эхэллээ. “Алтай бидний нийтийн гэр” гэсэн бодлогыг Монгол, Хятад, Орос, Казакстан дөрвөн улсын засгийн газруудын санаачилгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь баруун бүсийн босоо тэнхлэгийн хурдны замыг түшиглэн аялал жуулчлалын хамтарсан сүлжээ байгуулах зорилготой юм. Ингэснээр дөрвөн улсын иргэд хоорондын харилцаа өргөжиж, итгэлцэлийг бэхжүүлж, сайн хөршүүд, сайн түншүүд болж харилцан ашигтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Энэ нөхцлийг бүрдүүлэхэд Баруун бүсэд аялал жуулчлалын цогцолбор бааз байгуулж, улс бүсийн нэгдсэн аяллын маршрут

16. / <http://altayer.ru/maps/avtomobilnye-doroge-na-altae.html> /

сүлжээтэй болж аялал жуулчлалыг бүсийн эдийн засагт нөлөөлөхүйц салбарын түвшинд хүргэж хөгжүүлэх зорилт тулгарч байна. Үүнийг бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулахын тулд Монгол улсын Засгийн газар энэ оны эхний хагаст “Торгоны зам”-ын хүрээнд нүүдэлчдийн өв соёлыг сурталчилсан “Торгоны зам аялал жуулчлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төслийн нэгж байгуулан ажиллаж эхэллээ. Дээрх төсөл хөтөлбөрүүдийг нэгтгэж Хятадын торгоны зам төсөлтэй уялдуулан холбож Хятадын Алтай аймаг- Казакстан, ОХУ-ын Алтайн хязгаарын хотууд: -Барнаул, -Бийск, -Новосибирск, Алтайн БН улс-Тува, Хакас гэсэн аялал жуулчлалын маршрут гаргаж, аялал жуулчлалын хамтарсан кластерыг баруун бүсийн босоо тэнхлэгийг түшиглэн байгуулах асуудлыг шинээр авч үзэн судлах шаардлагатай.

Тав. Төмөр зам

Баруун бүсийн босоо тэнхлэгийн чиглэлд хоёр хөршийг холбосон транзит ачаа, зорчигч тээврийн төмөр замын томоохон мега төсөл орж байна. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын гуравдугаар үе шат буюу баруун босоо чиглэлийн төмөр замын судалгааны ажил энэ жилээс эхэлсэн. Судалгааны баг 2 жилийн дараа гэхэд ТЭЗҮ-г нь бэлэн болгох зорилт тавин ажиллаж байна. Төрийн бодлогод өргөн царигтай төмөр зам тавихаар тусгасан. Одоогоор ОХУ, БНХАУ хоорондын транзит тээвэртэй нийлээд жилдээ 100 сая орчим тонн, 2020 онд 200 сая тонн ачаа зөөх талаар яригдаж буй. Транзит тээврийн ачааллыг бууруулах зорилготой уг төмөр замын суурь бүтэц нь хүнд даацынх байх аж. Энэ төмөр зам БНХАУ-тай хиллэдэг Өмнөговийн Шивээ хүрэнгээс ОХУ-ын Туватай хиллэдэг Завханы Арц суурийн боомт хүртэл барих 1000 гаруй км төмөр зам байх юм¹⁷. Арц суурийн боомтоор ОХУ-ын Туватай эхлээд шинээр баригдах Эрдэнэт-Овоотын төмөр зам холбогдох юм. Энэ зам Монгол улсын Засгийн Газрын “Талын зам” төлөвлөгөөний бүтэц хэсэг бөгөөд үндэсний төмөр замын сүлжээг Эрдэнэт хотоос Аспайр компанийн Овоотын коксжих нүүрсний төсөл рүү өргөтгөх, улмаар ОХУ-ын хил рүү Арц Суурийн боомтоор холбох төлөвлөлт юм. Дараа нь ОХУ-ын Засгийн Газар тус төмөр замыг Арц Сууриас Транс-Сибирийн төмөр зам руу Кызыл хотын боомтоор холбох, тэгснээр Сибирь болон Монгол

17. Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого

улсын хойд бүс нутгийг Хятадтай холбох олон улсын төмөр замын холбоос үүсгэхээр төлөвлөж байна. Ингэснээр ОХУ-ын транзит ачааг Хятадын зах зээлд шууд хүргэх зам болж, Сибирийн өмнөд нутгийн ачааг тээвэрлэх зайг 1,250 хүртэл км-ээр ойртуулах боломжтой хэмээн тооцогдож байна. Төмөр замын нийт урт нь 547 км, шугамын нийт төсөвт өртөг нь 1.3 тэрбум ам. доллар байх аж¹⁸.

Дээрхи хоёр төсөл хэрэгжсэнээр ОХУ, Хятад, Монгол гурван улсын хоорондын болон Ази-Европын эдийн засгийг илүү өргөн хамрах худалдааны хэмжээг нэмэгдүүлж, Хятадын Зүүн бүсийн транзит тээврийн боомтуудын ачааллыг хөнгөвчлөх чухал ач холбогдолтой.

ДҮГНЭЛТ

Гурван талт стратегийн түншлэлийг Баруун бүсийн босоо тэнхлэгээр хөгжүүлэх хувилбар нь огтоос үл биелэх мөрөөдлийн “жагсаалт” биш. Хамтран ажиллах нөхцөл боломж нь гурван талаасаа бүрдсэн, гурвууланд нь үр өгөөжтэй болох нь олон талын судалгаагаар батлагдсан хувилбар юм. Тийм учраас энэ хувилбарыг дэвшүүлэхдээ олон нөхцөл болзол санал болгоогүй. Хятадын торгоны замын эдийн засгийн бүсийн номлол, Оросын Евро-Ази руу чиглүүлсэн бодлогыг угтуулаад Монголын Баруун бүсийн босоо тэнхлэг гурван талт стратегийн түншлэлд бэлэн байгаа шүү гэдгийг л хэлэх гэсэн хэрэг. Хэрэв энэ хувилбар дэмжигдвэл баруун бүсийн эдийн засгийн хөгжилд “гэрэл” асаж ложистик болон транзит тээврийн хөгжил шинэ шатанд хүрнэ. Бараа бүтээгдэхүүн ажиллах хүч, капиталын чөлөөт урсгал бий болно. Бүс нутгийн аялал жуулчлал олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ. Хамгийн чухал нь тэнд төрөл бүрийн үйлдвэрүүд, жижиг, дунд бизнес хөгжих шинэ боломжууд нээгдэнэ. Ингэснээр үй олон тогтвортой ажлын байр шинээр бий болж баруун бүсэд ажилгүйдэл байхгүй болно. Төв рүү тэмүүлсэн их нүүдэл зогсч, төвөөс зугтах хандлага бий болно. Баруун бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн ялгаа арилна. Төвийн болон Зүүн бүсийн босоо тэнхлэгийн ач холбогдлыг энд үгүйсгээгүй. Нэгэн зэрэг хөгжүүлж болох гурвалсан түншлэлийн нэгэн хувилбар нь Баруун бүсийн босоо тэнхлэг юм.

Түншлэлийн стратегийг глобал хүрээнд даяаршилтай уялдуулан авч үзэж орон зай, мэдээлийн урсгалыг товчлох өндөр хурдны

18. www.mongolianbusinessdatabase.com/base/newsdetials?id=1603...mn

шилэн кабель, агаарын замын шинэ урсгал бий болгож, урд хөршид “чимээгүй тахал” хэмээн нэрлэгдээд буй ундны цэвэр усны хомсдолыг даван туулахад хамтарч ус дамжуулах хоолой тавьж, хүмүүн хийгээд хөрөнгийн урсгалыг зохистой харьцаанд бий болгох өргөн боломжтой.